

Эдийн засгийн онцгой бүс (ЭЗОБ) байгуулсан нь Хятадад гадаадтай нээлттэй байх бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдсон нэг чухал шийдвэр юм. 1980 оноос Шэньжэнь, Жухай, Шаньтоу, Сямынь, Хайнань арал гэсэн 8 сая хүн амтай 34,6 мян. км² нутаг дэвсгэрийг хамарсан ЭЗОБ байгууллаа. Өнгөрсөн 10 жилд эдгээр бүс нь гайхам амжилтанд хүрч Хятадын өвөрмөц онцлогтой хөгжлийн замаар замнав.

Нэг. ЭЗОБ, түүний гол бодлого

1970-аад оны сүүлээр дотоод дахь эдийн засгийн байгуулалтын туршлага болон олон улсын эдийн засгийн байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр манай орон гадаадад нээлттэй байх явдлыг төрийн бодлого болголоо. Түүнчлэн Хятадын зүүн өмнөд далайн эрэг орчмын боомт хуацяо (цагаачид) олон, түүхий эдээр харьцангуй баялаг, зам харилцааны хувьд илүү тохиромжтойг харгалзан Гуан дун, Фузянь хоёр мужид гадаадтай нээлттэй байх бодлого хэрэгжүүлэх, Шэньжэнь, Жухай, Шаньтоу, Сямынь 4 хотод ЭЗОБ байгуулах шийдвэр гаргасан юм. 1980 оны 8-р сарын 26-нд хуралдсан БХАТИХ-ын 5 дахь удаагийн Байнгын хорооны 15-р хуралдаанаар «Гуандун муж дахь ЭЗОБ-ийн журам»-ыг батлав. Ийнхүү дээр дурдсан дөрвөн бүсэд хөрөнгө оруулж, барилга байгууламжийн ажил эхэлсэн нь Хятадад гадаадтай нээлттэй байх бодлогыг хэрэгжүүлэх чухал алхам боллоо.

1. Эдийн засгийн онцгой 5 бүсийн газарзүйн байрлал.

Шэньжэнь нь Гуандун мужийн Шэньжэнь хотын нэг хэсэг юм. Хөрш зэргэлдээ орших Гонконгоос 32 км, Гуанжоугаас 147 км алслагдсан бөгөөд 327,5 км² нутаг дэвсгэр нь Шэньжэнь хотын 16,2 хувийг эзэлнэ.

Жухай нь Аомэнь (Макао) -тэй хөрш зэргэлдээ оршино. Зүүн хэсэг нь Гонконгоос 36 миль (далайгаар), хойд хэсэг нь Гуанжоугаас 140 км зайтай. Нутаг дэвсгэрийн хэмжээ-121 км². Энэ нь Жухай хотын талбайн 9,5 хувь юм.

Шаньтоу нь хоёр хэсэгт хуваагдана. Нэг хэсэг нь Шаньтоу хотын зүүн дүүргийн Лунь нуурын 22,6 км² нутгийг хамарна. Нөгөө хэсэгт Шаньтоу хотын зүүн өмнө орших Асбань арал (30 км²) багтана. Ийнхүү Шаньтоугийн нийт талбай 52,6 км² ба Шаньтоу хотынхоо 0,5 хувийг эзэлнэ.

Сямынь нь Сямынь арлыг бүхэлд нь, мөн Гулан нэртэй жижиг арлыг багтаана. Нутаг дэвсгэрийн хэмжээ 131 км² нь Сямынь хотын 9,6 хувийг эзэлнэ.

Хайнань (1988 оны 4-р сарын 13-нд хуралдсан БХАТИХ-ын 7 дахь удаагийн Байнгын хорооны анхдугаар хуралдаанаар бие даасан муж, ЭЗОБ болгох шийдвэрийг албан ёсоор баталсан) -ий нутаг дэвсгэрийн хэмжээ 34 мян. км² бөгөөд одоогоор Хятадаа хамгийн том ЭЗОБ ажээ.

2. ЭЗОБ-ийн гол зорилго, үндсэн бодлого.

ЭЗОБ байгуулсан гол зорилго нь олон улсын зах зээлийг ашиглах, гадаадтай эдийн засаг, техникийн талын хамтын ажиллагаагаа идэвх-

*Хятадын эдийн засгийн шинэтгэлийн хорооны орлогч дарга

жүүлэх, худалдаа солилцоо хийх, гадаад хөрөнгө оруулалт, ашиглалтыг улам түргэвчлэх, тэргүүний техник технологи нэвтрүүлэх, гадаад орнуудад таваарын эдийн засгийг хэрхэн хөгжүүлж буй туршлагаас сурах арга зам хайх, экспортын чиглэлтэй эдийн засгийг хөгжүүлэн үүгээрээ Хятадын шинэчлэлтийн үйл хэрэгт хувь нэмэр оруулахад оршино.

Хятадын ЭЗОБ нь ерөнхий утгаараа зөвхөн эдийн засгийн онцгой район биш билээ. Тэр нь бүс нутгийн хэмжээ, үйлдвэрлэлийн бүтцийн хувьд төдийгүй үйл ажиллагаа, үүргийн хувьд онцгой юм. Энд гадаад орнуудад байдаг экспортын чиглэлийн болон боловсруулах үйлдвэр төвлөрснөөрөө онцлогийн дээр чөлөөт худалдааны бүсээс 4 шинжээр ялгаатай юм. Үүнд:

1. Эдгээр онцгой бүс нь Хятаддаа гадаадтай харилцах «цонх» юм. Нэг талаар гадаадаас хөрөнгө, техник технологи оруулах, үйлдвэрлэл эрхлэх туршлага нэвтрүүлж байгаа нь социализмын бүтээн байгуулалтад бүхэлдээ үр өгөөжтэй үйл ажиллагаа болж байна. Нөгөө талаар Хятадын гадаадтай харилцах бодлогод чухал үүд хаалга нээж байна

2. ЭЗОБ нь Хятадын шинэтгэлийн хүрээнд хийгдэж буй нээлттэй бодлогыг хэрэгжүүлэх төдийгүй аж үйлдвэр, хөдөө аж ахуй, худалдаа зэрэг эдийн засгийн бүхий л салбарт өөрчлөлт хийх туршилтын талбар болж байна.

3. ЭЗОБ-ийн нутаг дэвсгэрийн хэмжээ маш том,

4. Бүтээн байгуулалтад зориулах хөрөнгө оруулалтыг улсаас бус «гаднаас хийлгэж, дотооддоо хамтрах» зарчмыг баримтлан, олон сувгаар хөрөнгө оруулж байна.

Хятадын Засгийн газраас ЭЗОБ-д явуулж буй эдийн засгийн өвөрмөц бодлого нь дотоод дахь эдийн засгийн удирдлагын системээсээ 4 зүйлээр ялгаатай юм. Үүнд:

1. Онцгой бүсийн бүтээн байгуулалтыг гаднаас хөрөнгө оруулж ашиглахад чиглүүлж байгаа бөгөөд энэ нь өмчийн бүтцийн хувьд социалист байгуулал дахь гадаадын хөрөнгөөр буй болсон үйлдвэр зонхилсон олон хэвшилт аж ахуйн цогц юм.

2. Эдийн засгийн үйл ажиллагааг явуулахдаа төлөвлөгөөт эдийн засгийг зах зээлийн эдийн засагтай зохицуулах зарчмыг баримталж байна.

3. Эхлэн хөрөнгө оруулагчдад аль болох ашигтай хөнгөлөлт үзүүлэх, хил чөлөөтэй нэвтрэх боломж олгож байна.

4. Онцгой бүсийн Засгийн газарт эдийн засгаа удирдан явуулах харьцангуй давуу эрх эдлүүлж байна.

Хоёр. ЭЗОБ-ийн хөгжлийн явц

ЭЗОБ Шэньжэнь, Жухай, Шаньтоу, Сямынь нь байгуулагдаад 10 жил болохдоо эхний 6 жилд үндэс суурийг нь тавьж», дараагийн 4 жил «үйлдвэрлэл явуулан, төвшинг дээшлүүлж, ашиг олох» гэсэн үндсэн 2 шат дамжлаа.

Эхний шат 1980-1985 оныг хамарч байна. ЭЗОБ байгуулахаас өмнө Шэньжэнь багавтар тосгон, Жухай нь загасны аж ахуй, Шаньтоу газар тариалан голлосон хотын шинжгүй, аж үйлдвэрийн үндэс суурь ч тавигдаагүй нутаг байв. Далайн эрэг орчмын хаалттай хот Сямыньд орчин үеийн үйлдвэр, худалдаа огт хөгжөөгүй байлаа. Тиймээс ЭЗОБ байгуулсны дараах эхний хэдэн жил гол төлөв «харилцаа холбооны долоон асуудлыг нэг зэрэг шийдвэрлэх (цахилгаан эрчим хүч, мэдээлэл, засмал зам, агаарын зам, усан зам, хаягдал цэвэрлэх, үерийн хамгаалалт хийх), үндсэн барилга байгууламжид хөрөнгө оруулах

нөхцөлийг сайжруулах зэрэг ажилд маш их хүч хөдөлмөр, цаг хугацаа зарцуулсан байна. Үүний зэрэгцээ таваарын үйлдвэрлэл, худалдаа, жуулчлал, аж үйлдвэр, хөдөө аж ахуйг хөгжүүлсэн нь ЭЗОБ-ийг хөгжүүлэх бас нэг үндэс болсон юм.

Хоёр дахь шатанд экспортын чиглэлийн эдийн засгийг хөгжүүлэх алхам хийв (1986 оноос хойших үе). Онцгой бүсийг хөгжүүлэх үндсэн арга хэмжээ авсны дараа үйлдвэрлэл явуулах, үйлдвэрлэлийн төвшинг дээшлүүлэх, ашиг олох хоёр дахь шатанд аажимдаа шилжин, улмаар экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд ихээхэн хүч чармайлт тавих болжээ. Цаашдаа «аж үйлдвэр голлосон, үйлдвэр, худалдааг хослуулсан хөгжлийн цогцолбор» чиг шугам тодорхой боллоо.

Хэдэн жилд ЭЗОБ-д хийсэн зохицуулалтын үрээр «гадаадаас хөрөнгө оруулах, дотооддоо хамтрах» ажилд ихээхэн хүч чармайлт гаргажээ. «Гурван янзаар хөрөнгө оруулсан» үйлдвэр, аж ахуйн газар (хамтран хөрөнгө оруулсан, үйлдвэрлэлээ хамтран эрхэлсэн, зөвхөн гаднын хөрөнгөнд тулгуурласан) түлхүү барьж байгууллаа. Түүнчлэн «дотооддоо хамтран» түүхий эд боловсруулах, эд анги угсрах, төрөлжүүлж дахин боловсруулах гурван төрлийн үйлдвэр байгуулж, бүтээгдэхүүнээ худалдаалах болов. Эхний үеэр улсын үйлдвэртэй хамтарсан үйлдвэр, аж ахуйн газар байгуулж, үйлдвэр худалдаа хосолсон экспортын чиглэлийн эдийн засаг хөгжүүлэхэд анхаарсан байна.

Хөгжлийн энэ шатанд ЭЗОБ-д хэд хэдэн өөрчлөлт гарсныг дурдвал:

— таваарын үйлдвэрлэлийн туйлын хоцрогдмол байдлаас салж харьцангуй хөгжин өөрчлөгдөв.

— төрийн зааварчилгад хэт баригддаг байснаа өөрийн хүчин чадалд тулгуурлах болов.

— Хөдөлмөр их шаардсан боловсруулах үйлдвэрлэлээс техник технологи өргөн ашигласан, үндсэн аж үйлдвэр хөгжүүлэхэд шилжив.

— дотоодын зах зээлээс олон улсын зах зээлд аажмаар шилжив.

— дотоодын хөрөнгөнд тулгуурладаг байснаа гадаад хөрөнгө оруулалтыг голлох болов.

— Засгийн газраас эдийн засгийг удирдахдаа шууд бус дам байдлаар хяналт тавьж, олон улсын дүрэм журамд нийцүүлэх болсон.

Удирдлагын чиг шугамд гарсан өөрчлөлтийн дүнд ЭЗОБ-д экспортын чиглэлийн эдийн засгийн харилцаа түргэн хөгжлөө. Статистикийн мэдээгээр, 1989 онд ЭЗО дөрвөн бүсийн экспортын бүтээгдэхүүний хэмжээ 3 тэрбум 481 сая ам. долларт хүрсэн нь улсын нийт экспортын 1/15 ээс илүү хувийг эзлэх болов. Энэ үзүүлэлтийг 1985 оныхтой харьцуулахад 4,27 дахин нэмэгджээ. Ялангуяа Шэньжэнь харьцангуй түргэн хөгжиж байна. 1989 онд экспортын нийт хэмжээ 2 тэрбум 170 сая ам. долларт хүрсэн нь 1985 оныхтой харьцуулахад 3,85 дахин өсжээ.

Экспортоос олох валютын чадавхи нэмэгдсэнээр ЭЗОБ-ийн экспортын бүтцэд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан юм. Үүнд:

1. Аж үйлдвэрийн экспортын бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэн 1989 онд Шэньжэнь, Жухай, Сямынь 3 бүсэд 9 тэрбум 444 сая юаньд хүрсэн нь аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний өртөгт эзлэх хувийн жингээр давуу байна. 1985 онд энэ үзүүлэлт 21,85 хувь байснаа 1989 онд 46,78 хувьд хүрчээ. Түүнээс Шэньжэний үзүүлэлт 1985 онд 37,1 хувь байсан бол 1989 онд 58,4 хувь болтлоо нэмэгдсэн байна.

2. Электрон машин техникийн экспорт нэмэгдэв. 1988 онд онцгой район 1 сая гаруй өнгөт телевизор экспортолсон нь нийт экспортын бүтээгдэхүүний 70 хувь, улсын хэмжээнд үйлдвэрлэсэн экспортлох өнгөт телевизорын талаас илүү хувийг эзэлж байлаа. 1990 оны эхний 5 сарын байдлаар нийт 1 сая 800 мянган телевизор экспортолсон нь дэлхийд тэргүүлж байв. Үүний тал хувийг Сямыньд үйлдвэрлэсэн аж.

3. «3 янзаар хөрөнгө оруулан» барьж байгуулсан үйлдвэрүүдийн экспортын бүтээгдэхүүний хэмжээ, түүний эзлэх хувийн жин өсөв. 1989 онд Шэньжэньд энэ үзүүлэлт 1 тэрбум 14 сая ам. долларт хүрсэн нь эндхийн нийт экспортын бүтээгдэхүүний 46,6 хувийг эзэлж байлаа. Шаньтоуд дээрх үзүүлэлт 123 сая ам. доллар ба 41,1 хувь болж байна.

4. Экспортоос валют олж буй газар аажмаар олшров. 1989 онд Шэньжэньд 1 сая гаруй ам. долларын орлоготой 300 гаруй үйлдвэр, аж ахуйн газар байлаа. Түүнээс 40 гаруй нь 10 сая гаруй ам. долларын орлого олжээ. Шэньжэнь нь мөн Америк тив, баруун Европ, Австрали Дундад дорнодод 10 гаруй худалдааны цэг, үйлдвэр, аж ахуйн газар байгуулсан юм. 1989 онд тэдгээр үйлдвэр, аж ахуйн газар нийтдээ 300 сая гаруй ам. долларын орлого олсон байна.

ЭЗОБ өнгөрсөн 10 жилийн хөгжлийн дүнд аж үйлдвэр голлон, худалдаа, санхүү, жуулчлал, орон сууц, хөдөө аж ахуйг хавсарсан эдийн засгийн цогц хэлбэрийг буй болгон, экспортын чиглэлээр эдийн засгаа хөгжүүлэх болсныг бодит байдал гэрчилж байна.

Гурав. **ЭЗОБ-ийн ололт амжилт**

1. Онцгой бүсэд үндсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэн өдрөөс өдөрт боловсронгуй болгосноор анхны алхамд хөрөнгө оруулах нөхцөл бололцоог бүрдүүлж өгөв. 1989 оны сүүлээр, дээрх 4 районд 30 тэрбум 534 сая юаний хөрөнгө оруулан, аж үйлдвэрийн газар бүрэн тоноглон засмал зам, усан цахилгаан станцын шугам сүлжээ, харилцаа холбоо, хөлөг онгоцны буудал, худалдаа жуулчлалын төв, орон сууцны барилга олноор нь бариллаа. Тухайлбал, дунд зэргийн хэмжээний онгоцны 2, шууд нислэгийн 2 буудал барьж 20 гаруй улс, дотоодын 100 гаруй хоттой шууд утсан харилцаатай болов. Мөн 40 сая тонн ачаа эргэлтийн хүчин чадалтай боомт шинээр барьжээ.

2. ЭЗОБ-д хөнгөлөлттэй хууль тогтоомж нэлээд үйлчилж байна. Бүх шатны АТИХ болон Засгийн газраас гааль, гаднаас хөрөнгө оруулсан банк, Хятад болон гадаад аль нэг оронтой хамтарсан банк, ЭЗОБ-ийн гаалийн үйл ажиллагааны тухай, таваарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг удирдах, гадаадтай хамтарч ажиллах, техник оруулах, хоршсон пүүс байгуулах болон үйлдвэрлэлийг зогсоох талаар 30 гаруй хууль тогтоомж гаргалаа. Үүний хамт ЭЗОБ-ийн засаг захиргааг өөрчилж дотоод, гадаадаас хөрөнгө оруулагчдыг бүртгэлтэй болгон, зөвшөөрөл олгох ажил эрхлэх журмыг төгөлдөржүүлж, ЭЗОБ-д хөрөнгө оруулах нөхцөл бүрдүүлж өглөө.

3. Гаднаас хөрөнгө оруулж, ашиглах ажил маш амжилттай явагдаж байна. 1989 оны сүүлийн байдлаар 4 районд 8 тэрбум 600 сая ам. долларын хөрөнгө оруулсаны 3 тэрбум 800 саяыг нь цэвэр ашиглан 5000 гаруй байгууламж барих хэлэлцээр хийжээ. Энэ нь мөн хугацаан дахь улсын хэмжээний үзүүлэлтийн 1/4-ийг эзэлж байна. Одоо гаднаас хөрөнгө оруулан барьсан 3300 гаруй үйлдвэр, аж ахуйн газар байна. ЭЗОБ-д гаднаас хөрөнгө оруулахдаа тооны талыг хараад зогсохгүй агуулга, чанар, төвшинг дээшлүүлэхэд ихэд анхаардаг. Гол хэмжүүр нь:

а) экспортын чиглэлээр үйлдвэрлэл явуулдаг газар гол байр эзэлнэ. Жишээ нь: 1989 онд Сямыньд энэ чиглэлээр хэлэлцээр хийсэн газар 8 гаруй хувийг эзэлж байв;

б) гадаад худалдааны чиглэлээр хөрөнгө оруулалтын цар хүрээ улам нэмэгдэж байна. Жишээ нь: Сямыньд гаднаас дангаараа нийлүүлэгчдийн оруулсан хөрөнгө урьд нь 1 сая 500 мян. ам. доллар орчим байснаа 3 сая 760 орчим мян. ам. доллар болж өсжээ.

в) ганц нэг үйлдвэр барихад хөрөнгө оруулдаг байснаа бүтэн цогц хэлбэрийн үйлдвэрлэл явуулахыг эрмэлзэх болов. Жишээ нь: Шэнь-

жэнь Гонконгийн Лизяачэн бүлгийнхэнтэй 3 тэрбум гонконг долларын хөрөнгө оруулан, хамтран ажиллаж, футянь хэмээх аж үйлдвэрийн район байгуулахаар хэлэлцэн тохирчээ;

г) хөрөнгө оруулах хугацааг уртасгав. Урьд нь 15-25 жил байсан бол одоо дийлэнх гэрээ хэлэлцээр 20-30 жил, хамгийн удаан нь 70 жилийн хугацаатай болгосон,

4. Техник технологи оруулах талаар тодорхой амжилт олов. Техник технологи үйлдвэрлэх төвшин ч нэмэгдлээ. Хэдэн жилд Шэньжэньд тэргүүний техник технологи, төхөөрөмж оруулсны 80 хувь нь 1970-аад оны сүүлч 80-аад оны эхэн үеийн олон улсын төвшинд хүрсэн байв. ЭЗО дөрвөн бүсэд ийнхүү хөрөнгө, техник технологи оруулснаар 1000 төрлийн шинэ бүтээгдэхүүн гаргах болсны зарим нь Хятадад урьд хожид байгаагүй зүйл ажээ. Жишээ нь: Шэньжэнь халуун хэмжигчийн соронзон толгой, лазерийн багаж, шил үйлдвэрлэх шугам, Жухай цахилгаан дамжуулах олон давхар шугамын самбар, Сямынь агаарын болон усан тээвэрт аянгаас сэргийлэгч, өнгөт зургийн Кодак хальс үйлдвэрлэх төхөөрөмж гаргах болов.

5. Эдийн засгийн хөндлөн холбоо эрчимтэй хөгжиж салаа салбар нь улам олширч байна. Ойрын жилүүдэд ЭЗОБ-д Хятадын бусад муж, хот, яам, үйлдвэр, аж ахуйн 4000 гаруй газар хөрөнгө оруулж хамтран ажиллав.

Үүний зэрэгцээ дотоодын үйлдвэр, аж ахуйн газруудад ЭЗОБ-ээс их хэмжээгээр хөрөнгө оруулан, хамтын аж ахуй эрхэлж харилцаа тогтоон, түүхий эд, жижиглэн худалдаалах бараа, экспортын бараа үйлдвэрлэх газар олноор байгуулж байна. Иймэрхүү хамтын ажиллагаа нь ЭЗОБ болон дотоодын үйлдвэр, аж ахуйн газрууд бие биеэ нөхсөн экспортын чиглэлийн эдийн засгийг хөгжүүлэх нөхцөл бүрэлдүүлэв. Нэг талаас дотоодын түүхий эд, анхдагч бүтээгдэхүүнийг ЭЗОБ-д боловсруулан экспортолж, дотоодын валютын чадварыг дээшлүүлэх, нөгөө талаас ЭЗОБ-д гаднаас оруулж өөрийн болгосон тэргүүний техник, технологи, төхөөрөмж, удирдлагын арга барилыг орон нутагт нэвтрүүлэн дотоодын техникийн дэвшил, эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлж байна.

6. Эдийн засгийн системд зоригтой шинэтгэл хийж, эхний шатанд төлөвлөгөөт удирдлага бүхий зах зээлийн систем бүрэлдүүлэв. Гадаадтай нээлттэй байх бодлогыг хэрэгжүүлэх, экспортын чиглэлийн эдийн засгийг хөгжүүлэхийн тулд ЭЗОБ-ийн олон салбарт өөрчлөлт шинэчлэлт хийлээ. Ялангуяа үндсэн удирдлагын системд төлөвлөлт, үйлдвэр, аж ахуйн газрын бүтцэд, үнэ, санхүү мөнгөн гүйлгээ, нийгмийн зохицуулах зах зээл, түүнчлэн үйлдвэрийн түүхий эдийн, оршин суух газрын, хөдөлмөр эрхлэлтийн, үнэт цаас солилцооны, техникийн мэдээллийн зэрэг зах байгуулж, аажимдаа олон улсын дүрэм журамд нийцсэн аж ахуй эрхлэн хөтлөх эдийн засгийн орчин буй болголоо. Энэ нь үйлдвэр, аж ахуйн газар оршин тогтнох бүрэн нөхцөл бүрэлдүүлж байна

7. Эдийн засгийн хүчин чадал нэмэгдэж, харьцангуй өндөр хурдацтай хөгжиж байна. 1989 онд ЭЗО дөрвөн бүсийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 21 тэрбум 100 сая юаньд хүрсэн нь 1985 оны хоос 3,85 дахин, ЭЗОБ байгуулагдахаас өмнөх үеийн үзүүлэлтээс 21 дахин нэмэгджээ. Шэньжэнь жижиг гацаанаас орчин үеийн том хот боллоо. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 1979 онд 60 сая юань байснаа 11 тэрбум 646 сая юань болтлоо өсжээ. Жилийн дундаж өсөлт 63 хувьд хүрэв. Жухайн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ 2 тэр бум 919 сая юаньд хүрсэн нь 10 жилд 23 дахин өссөн байна. Шаньтоуд үйлдвэр, аж ахуйн газар огт байхгүй байсан бол одоо тэдгээрийн тоо 440 болжээ. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ 920 сая юаньд, Ся-

мынийх 5 тэрбум 625 сая юаньд хүрсэн нь 1979 оны хоос 7 дахин нэмэгдсэн байна.

8. ЭЗОБ Хайнань хөгжлөөрөө бусдаас 2 жилээр түрүүлж явна. 1989 онд их барилгын хөдөлшгүй хөрөнгө 1 тэрбум 185 сая юаньд хүртлээ нэмэгджээ. Цахилгаан эрчим хүч, зам харилцаа, холбоо зэрэг үндсэн барилга байгууламжийг барьж байгууллаа. Хөрөнгө оруулалтын орчин мэдэгдэхүйц сайжирч, гадаадаас хөрөнгө оруулах алхаагаа хурдасгалаа. Хоёр жилийн дотор гаднаас хөрөнгө шууд оруулж ашиглах талаар нийтдээ 841 хамтарсан гэрээ байгуулсан ба гэрээ ёсоор 663 сая ам. долларын хөрөнгө оруулахаас бодит байдал дээр 223 сая ам. долларыг ашиглаад байна. Энэ нь муж болон ЭЗОБ байгуулахаас өмнөх 8 жилийн үзүүлэлтүүдээс 2,9; 2,3; 2,4 дахин нэмэгдсэн байна. 1989 онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний хэмжээ 2 тэрбум 524 сая юаньд хүрсэн нь 1987 оныхоос 31 хувиар нэмэгдэж, гадаад худалдаа экспортын хэмжээ 354 сая ам. долларт хүрсэн нь 3.1 дахин өсжээ. Түүнээс аж үйлдвэрийн экспортын бүтээгдэхүүний хэмжээ 137 сая ам. долларт, «3 янзаар хөрөнгө оруулан» барьсан үйлдвэр, аж ахуйн газрын экспортын бүтээгдэхүүний хэмжээ 19 сая ам. долларт хүрсэн нь харьцангуй хурдан өссөн байна.

Дөрөв, ЭЗОБ-ийн үндсэн туршлага

Бидний туулж ирсэн 10 жилийг эргэн харахад ЭЗОБ-ийн хөгжлийн амжилт доорх хэдэн зүйлтэй холбоотой. Үүнд:

Социалист шинэтгэл, нээлттэй бодлогыг дэмжсэн нь ЭЗОБ бадран хөгжихийн үндэс болов. ЭЗОБ-ийн бүтээн байгуулалтын амжилт нь тус бүс нутгийг шинэтгэл, нээлттэй бодлогын туршилтын талбар болгосон анхны шийдвэр зөв зүйтэй болохыг харуулаад зогсохгүй, социалист системийн давуу талыг тод харууллаа. Зөвхөн нэг төв, хоёр үндэслэлийг дэмжсэнээр, шинэтгэл, нээлттэй бодлогыг хэрэгжүүлснээр социалист системийн давуу тал бүрэн дүүрэн биеллээ олох юм. ЭЗОБ-ийн хөгжлийн явцад урагшлан давших бүхэн шинэтгэл, нээлттэй бодлогод тулгуурлана, ЭЗОБ-ийг урагш хөгжүүлэе гэвэл урьдын адил шинэтгэлийг гүнзгийрүүлж, нээлттэй бодлогыг өргөжүүлэх хэрэгтэй.

2, ЭЗОБ нь экспортын чиглэлээр эдийн засгаа хөгжүүлэх замаар замнаж байна. Өнгөрсөн жилүүдэд ЭЗОБ-д экспортын чиглэлээр эдийн засгаа хөгжүүлэх талаар их ч ажил хийж, нэлээд туршлага хуримтлууллаа. Үүнд:

а) экспортын чиглэлээрх эдийн засгийн стратеги төлөвлөгөөг батлав. Үйлдвэрлэлийн бүтэц, үйлдвэрлэл эрхлэлт, арга барил, төлөвлөлтийг өөрчлөхөд хүч тавьж, олон улсын худалдаа, солилцоо, өрсөлдөөнд оролцох боллоо.

б) ЭЗОБ-ийн үйлдвэр, аж ахуйн газрууд, дотоодын бүтээгдэхүүнээ худалдан аваад экспортолдог байсан бол бүтээгдэхүүнээ өөрөө үйлдвэрлэж экспортолдог, түүхий эд боловсруулж, эд анги угсардаг байснаа «гадаадаас ширхгээр авч, дотоодод үйлдвэрлэдэг болов. Мөн орон нутагт экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрийн үндсийг тавьж, хилийн чанад дахь улс орнуудтай худалдаа хийхдээ шууд бус байдлаар хийдэг байснаа шууд харилцах болов.

в) яваандаа «түүхий эд оруулан боловсруулж- экспортлох» гэсэн экспортын чиглэлээр эдийн засгаа хөгжүүлэх хэлбэр буй болгов.

г) үр өгөөжтэй янз бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлэн, экспортоос валют олох үйлдвэр, аж ахуйн газрыг олшруулахад их анхаарч байна.

3. Дэд бүтцийг хөгжүүлэхэд ихэд анхаарч, хөрөнгө оруулах таатай орчин бүрдүүлжээ. Харилцаа тогтоох, юуны түрүүн «5 төрлийн харил-

цаа ба нутаг дэвсгэрийн тэгшитгэл» (усан зам, цахилгаан, шуудан холбоо, усан хангамж, зам тээвэр ба газар нутгийн тэгшитгэл; эсвэл «7 төрлийн харилцаа ба нутаг дэвсгэрийн тэгшитгэл хийж гүйцэтгэх шаардлагатай байна. Энэ нь ЭЗОБ-ийн бүтээн байгуулалтын явцдаа олсон нааштай туршлага болов. ЭЗОБ байгуулахдаа гадаад дотоодын эрдэмтдийн саналыг хамтатган ерөнхий төлөвлөгөө боловсруулж, үүндээ төлөвлөлт, газраа тогтох, ерөнхий стандарт, газар доорх байгууламж, янз бүрийн бүс нутгийн үйлдвэрлэх хүчний байршлыг тогтоох, барилгын зураг төсөл хянах, харилцан шаардлага тавих, ногоожуулах гэсэн найман чиглэлээр нэгдсэн бодлого явуулахаар тусгажээ. Ингэснээр хөрөнгө мөнгө хэмнэх талаар сайн үр дүнд хүрсэн юм.

4. Бие даан янз бүрийн сувгаар мөнгө олж, барилга байгууламж барих явдал Хятадын ЭЗОБ-ийн нэг чухал туршлага болов. Олон орон худалдааны чөлөөт бүс, экспортын боловсруулах үйлдвэрийн бүс зэргийг байгуулахдаа улсаас хөрөнгө авдаг. Манайх ч гэсэн зарим бүс нутагт улсаас төвлөрсөн журмаар хөрөнгө гаргасан. Харин манай ЭЗОБ ийн эрэлт хэрэгцээ маш их тул улсын дэмжлэгтэйгээр орон нутгийн захиргаа, үйлдвэр, аж ахуйн газар гадаадаас хөрөнгө оруулах, банкны зээл авах, өөрсдөө хөрөнгө хуримтлуулах зэргээр шийдвэрлэхээс гадна, гадаадынханд бие даан хариуцах бүрэн эрх олгож байна. Жишээ нь: Шэньжэньд 1979 оноос 1983 онд их барилгад оруулсан хөрөнгийн 30,9 хувь нь гадаад хөрөнгө, 29,3 хувь банкны зээл байв.

Ийнхүү ЭЗОБ-д ихээхэн аз туршсан нөхцөлд хөрөнгө оруулалтын ашиглалтыг сайжруулж, эдийн засаг, нийгмийн үр ашигт улам бүр анхаарал хандуулж байна. ЭЗОБ-үүд их барилга болон бие даасан гэрээт хариуцлагын системийн хэрэгжилтээр улсдаа тэргүүлж байгаа юм. Жишээ нь, их барилга дээр 7 хоногт 1 давхар, зарим үед 3 өдөрт 1 давхрыг босгож байна. Энэ нь олон улсын төвшинд хүрч ЭЗОБ-ийн барилга байгуулалтыг түргэтгэв.

1990-ээд оны хувьд, Хятадын ЭЗОБ хөгжлийн шинэ үе шатанд орлоо. Шинэтгэлийг цаашид гүнзгийрүүлж, үйлдвэрийн бүтцээ чамбайруулж, техникийн дэвшлээ түргэтгэх юм. Мөн хөрөнгө оруулах нөхцөл, эдийн засгийн үр ашгийг сайжруулж олон улсын өрсөлдөөнд (харил цаанд) өргөн хүрээнд ул суурьтай оролцож, Хятадын онцлогтой социализм байгуулахад хувь нэмэр оруулна.

ЯПОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРЧИМТ ХӨГЖЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛҮҮД

М. Нарантуяа*

Ази тивийн Япон улс нь ХХ зууны II хагаст эдийн засгийн гайхамшгийг үзүүлсэн билээ. Японы эдийн засгийн эрчимт хөгжлийн хүчин зүйлүүд нь юу болох, тус улсын эдийн засгийн бодлогын нууц нь чухам юундаа байгааг олон орны эрдэмтэд сонирхон, нарийвчлан судалсаар байна. Японтой нэг тивд оршиж, зах зээлийн эдийн засагт шилжиж буй манай улсын хувьд энэ асуудал бүр ч сонирхолтой нь мэдээж билээ.

*Дорно дахин олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан